



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар 2010 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1.4, "Ан агнуурын тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Ахуйн зориулалтаар 2010 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг 1 дүгээр, үйлдвэрлэлийн зориулалтаар 2010 онд барих агнуурын загасны тоо хэмжээний дээд хязгаарыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү тушаалыг 2010 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/, Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт даалгасугай.

Гурав. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар 2009 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2008 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 46 дугаар тушаалыг 2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Л. ГАНСҮХ

Улсын бүртгэлд 2009 оны 12 дугаар сарын 31-ний 3102 дугаарт бүртгэсэн